

Living the Lotus 10

Buddhism in Everyday Life

2025
VOL. 241



Америк дахь гишүүд 8 сарын 10-нд Лос-Анжелас хотод болсон
“Nisei Week, 2025” Япон үндэстний баярын жагсаалд оролцов.



Photo@EricXiong

Living the Lotus Vol. 241 (2025.10)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ном уншихын ач холбогдол

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Эрдэмтэн мэргэдтэй нөхөрлөхүй

Намар цаг ирэхээр “ном унших улирал” гэж хэлж ярилцах нь их сонсогдоно. Би өмнөх дугаарт сурч мэдэх талаар дараагийн дугаарт гүнзгийрүүлэн бичнэ гэж хэлсэн. Сурч мэдэхэд ном унших нэн чухал бөгөөд хамгийн ойрхон зүйл гэж би боддог.

Эдогийн сүүл үеийн сэтгэгч Ёшида Шооин (1830–59) *Гэнпүкү* баяр (т ухайн үеийн насанд хүрсний баяр ба 15 орчим насанд тэмдэглэдэг байсан)-аа тэмдэглэж байгаа үеэлдээ “Самурайн долоон зарчим” гэсэн гарчигтай захиа бичсэн байдаг. Эл захидалд “Хүний амьдралыг туулахдаа эрт эдүгээгийн үнэний хуулийг дагахгүй, эрдэмтэн мэргэдээс багшаа хэмээн суралцахгүй бол гагц өөрийн эрх ашийг л боддог ядуу сэтгэлгээтэй хүн болж хоцорно. Номоор дамжуулан эрдэмтэн мэргэдтэй нөхөрлөх нь буянт хүмүүний үүрэг болой.” хэмээн ном унших нь эрдэм мэдлэгийг гүнзгийрүүлэх чухал ач тустай болохыг сургажээ.

Эртний Грекийн гүн ухаантан Сократ ч гэсэн “Ном унших нь хичээж зүтгэж олж авсан мэдлэгээ өөрийн болгож, өөрийгөө хөгжүүлэх хамгийн амархан арга.” гэж хэлсэн. Аугаа гайхамшигтай хүмүүсийн үзэл санаа, ном бичвэрээс хүний амьдралын зөв зам мөрийг суралцах нь аль ч үе адилхан байсан ажээ.

Эрдэмтэн мэргэдийн сургаалаар зогсохгүй бусад олон төрлийн ном зохиолоос сэтгэл догдлол, гайхшралыг мэдэрч, хүний уй гашуу, баяр хөөрийг амталдаг ба тэр болгон нь сэтгэл мэдрэмжийг хөгжүүлэх амин дэм болдог. Өнөө үед номын дэлгүүр цөөрч байгаа ба цахимыг илүүд үзэх хүмүүс “одоо цаасан ном хоцрогдсон шүү дээ” гэж шоолон инээж магадгүй. Гэвч ном нь ямар ч насны хүнд бие сэтгэлийн гайхамшигтай нөлөө үзүүлдгийг олон судалгаа баталдаг.



Цаасан номны ашиг тус

Нэгэн судалгаанаас үзвэл хүн ном зохиол уншихаар тэнд гарч буй үйл явдлыг төсөөлөн бодож, дүрүүдийн сэтгэлзүйг мэдэрдэг ба үүгээр дамжуулж өөрийгөө танин мэдэхийн зэрэгцээ хүний нөхцөл байдал, сэтгэл санааг ойлгох, мэдэрч хүлээж авах чадвар хөгжиж, бусдыг хайрлаж хүндлэх мэдрэмж гүнзгийрдэг ажээ. Мөн бага насандаа ном их уншсан хүн уншаагүй хүнээс 3 дахин их үгийн баялагтай байдаг гэсэн судалгаа ч бий.

Мөн Английн ерөнхий сайд асан Чарлис Линтон Блэйр “7 настай хүүхдүүдийн уншсан номын тоо 20 жилийн дараах Англи улсын үнэ цэнийг тодорхойлно.” гэж хэлсэн байдаг. Энэ үгний цаана номоор дамжуулж хүний сэтгэл мэдрэмж, эрдэм мэдлэгийг тэнцвэртэй хөгжүүлснээр ард иргэд нь өндөр мэдлэг боловсролтой, уужуу сэтгэлтэй нөхөрсөг болдог ба тэр хэмжээгээрээ улс орон хүчирхэг болно гэсэн утга агуулагдаж байгаа болов уу.

Бид ухаалаг утаснаас “мэдээлэл” авдаг бол математикч Фүживара Масахико гуай “Ном уншсанаар тусдаа оршиж байсан мэдээлэл зохион байгуулалтанд орж мэдлэг болж хувирдаг ба мэдлэг нь туршлага, эргэцүүлэл, сэтгэл мэдрэмжийн тусламжтайгаар хүмүүжил боловсрол болдог.” («Номын дэлгүүрийг хамгаалцгаая», РНР судалгааны төв) гэсэн байна. Өөрөөр хэлбэл “мэдээлэл”-д зөв үнэлэлт дүгнэлт хийхэд хүмүүжил боловсрол, сэтгэлийн нарийн мэдрэмж шаардлагатай ба үүнийг хөгжүүлдэг мэдрэх, эргэцүүлэн бодох чадвар нь ном уншсанаар хөгждөг ажээ.

Мөн сэтгэл тайвшруулах, стресс тайлах, зөнөгрөх өвчнөөс сэргийлэх гэх мэт цаасан номны ашиг тус маш их. Бидний хувьд бол Шагжамүни бурхан, Күнзийн сургаалыг судар номноос л уншиж мэдэж байгаа билээ. Намтар түүх их унших тусам олон хүмүүсийн амьдралаас суралцах сайхан боломж болдог. Түүнчлэн ирээдүйг залгамжлах хүүхэд багачуудыг номонд дуртай болгох нэн чухал ба ном барьж үзэх, аав ээжийнхээ ном уншиж өгөх дуу хоолой, үг яриаг сонсох зэрэг нь бүгд хүүхдийн тархи оюуныг хөгжүүлж, хүнлэг мөн чанар, эрдэм мэдлэгийг тэлдэг билээ.

Би өөрөө ч гэсэн хүн хэрхэн амьдарвал зохилтойг сурч, сэтгэлээ хөгжүүлэхийн төлөө номыг таашаан уншдаг ба хүүхдүүд жаахан байхад унтахынх нь өмнө ном уншиж өгч байгаад өөрөө түрүүлээд унтчихдаг байж билээ. Гэхдээ тийм цаг мөч ч гэсэн эцэг эх, хүүхдийн мэдрэмжийг хөгжүүлэх чухал “номын дурсамж” гэж бодож байна. Тиймээс өөрийгөө өнгөлж зүлгэх гэдэг утгаараа ч, үр хүүхдээ хүмүүжүүлэх гэдэг утгаараа ч намрын урт оройг хааяа ном уншиж эрдэм мэдлэгээ тэлэхэд зориулан таатай өнгөрүүлж, үүнийг амьдралынхаа нэгэн дадал болгоод үзвэл ямар вэ?

«Косей» сэтгүүл, 10-р сарын дугаараас



Намрын орой эрдэм мэдлэгээ гүнзгийрүүлэх нь

Акагава Кэйичи

Та бүхэн сайн байцгаана уу?

Намрын хиган (зунаас намарт шилжих 1e) өнгөрсөн ч Японы аралд зуны халуун үргэлжилсээр. Харин танай оронд ямар байна вэ?

Жил бүр намар болохоор “ном унших улирал”, “намрын урт орой”, “ном уншиж дадах” гэсэн үгнүүд сонсогддог юм. Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа “сэтгэлээ сайжруулах” нэгэн арга барил болгон амьдралдаа “ном унших”-ыг дадуулах талаар сургажээ. Олон янзын ном зохиолд дуртай тэрбээр өөрийн өнцгөөр ном уншихын ашиг тусыг олон жишээ татан тайлбарласан байна.

Уншигч та бүхэн цаасан ном, цахим ном хоёрын алийг нь дэмждэг вэ? Сүүлийн жилүүдэд уламжлалт цаасан номноос гадна цахим номыг дэлгэцээс уншиж таашаах хүн нэмэгдэж байна. Ийм цаг үеийн урсгалд тааруулан манай нийгэмлэгийн эрхлэн гаргадаг 52 жилийн түүхтэй “Dharma world” сэтгүүл ч гэсэн энэ намраас цахим хэлбэрт шилжсэн. Энэ дашрамд тус мэдээллийг дамжуулахын зэрэгцээ цаашид ч гэсэн таалан уншиж байгаарай хэмээн хүсэж байна.

Ном ямар ч хэлбэртэй байсан сэтгэлийг хөгжүүлэх тал дээр адилхан. Би өдөр тутмын завгүй үйл явдалд дарагдан, хоосон үгээр өөрийгөө өөхшүүлэхгүй байхад энэ сар анхаарч, энэ сарын сургаалаар дамжуулан Цагаан лянхуа сударт айлдсан энэрэн нигүүлсэхүй ба бэлгэ билиг гэдгийг энэ намар улам бүр мэдэрье гэж бодлоо. Та бүхэн ч гэсэн хамт хэрэгжүүлээд үзээрэй.



9 сарын 6-нд Солонгос нийгэмлэгт зохион байгуулагдсан Урабон ёслолоор цэцэг өргөх үүрэг авсан гишүүдтэй ярилцаж байгаа нь.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp